

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МЯНГАД ШИМ УС ОНӨААТҮГ-н 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/5/СТА-ОНӨААТҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Аудитор: Ц.Гантулга Утас: 70432545</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын тамгын газар</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/.....	5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/.....	5
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/.....	6
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/...	7
3. АУДИТЫН ТАЙЛАН.....	7
3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	7
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	7
3.4. Материаллаг байдал	8
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	8
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	9
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
3.9. Аудитын илрүүлэлт.....	10
Залруулсан алдаа.....	10
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	10
Аудитын зөвлөмж.....	10
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	10
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	10
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	11

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

МЯНГАД СУМЫН ШИМ УС
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Ж.БАТОЧИР ТАНАА

2021.01.15 № 2/135
танай _____ -ны № _____ -г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мянгад сумын Шим ус ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мянгад сумын Шим ус ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, цэвэр бохир усны үйлчилгээг албан байгууллага, ард иргэдэд хөнгөн шуурхай, хүртээмжтэй хүргэх санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

021020706

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,116,479.29</u>	<u>2,004,441.92</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	656,925.70	18,303.80
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	656,925.70	18,303.80
31213	Арилжааны банк дахь харилцах	656,925.70	18,303.80
33	АВЛАГА	42,326.59	74,471.09
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	42,326.59	74,471.09
35	БАРАА МАТЕРИАЛ	1,417,227.00	1,911,667.00
354	Хангамжийн материал	1,417,227.00	1,911,667.00
35420	Аж ахуйн материал	1,417,227.00	1,911,667.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,137,035.00	3,137,035.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-859,415.00	-1,486,822.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,394,099.29</u>	<u>3,654,654.92</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>199,466.30</u>	<u>345,912.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	199,466.30	345,912.00
413	Өглөг	199,466.30	345,912.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	199,466.30	67,389.00
4136	Бусад өглөг		278,523.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	278,523.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,194,632.90</u>	<u>3,308,742.92</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,194,632.90	3,308,742.92
512	Хуримтлагдсан үр дүн	4,194,632.90	3,308,742.92
51210	Өмнөх үеийн үр дүн	3,564,396.00	4,194,632.90
51220	Тайлант үеийн үр дүн	630,236.90	-885,889.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,394,099.20</u>	<u>3,654,654.92</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>29,903,986.00</u>	<u>32,397,653.00</u>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	29,903,986.00	32,397,653.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>29,273,748.70</u>	<u>33,283,542.98</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>29,273,748.70</u>	<u>33,283,542.98</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,273,748.70	33,126,274.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,284,853.00	15,889,916.00
210101	Үндсэн цалин	16,284,853.00	15,889,916.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,007,650.95	4,344,125.00
210201	Тэтгэврийн даатгал	2,007,650.95	4,344,125.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,214,785.00	5,139,130.00

210301	Гэрэл, цахилгаан	5,214,785.00	5,139,130.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,746,900.00	6,004,700.00
210401	Бичиг хэрэг	203,700.00	45,000.00
210402	Тээвэр, шатахуун	465,100.00	77,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,888,100.00	5,882,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,900.00	1,314,203.87
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		90,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	53,900.00	1,224,203.87
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	737,659.75	434,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,252.75	434,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	630,237.30	-885,889.98
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	630,237.30	-885,889.98

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	29,917,127.00	32,397,653.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	29,917,127.00	32,397,653.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	29,917,127.00	32,397,653.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	29,273,342.92	33,036,274.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,273,342.92	33,036,274.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		20,668,241.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,284,853.00	15,889,916.00
210101	Үндсэн цалин	14,584,853.00	15,889,916.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,050,988.92	4,344,125.00
210301	Гэрэл, цахилгаан	5,214,785.00	5,139,130.00
210401	Бичиг хэрэг	203,700.00	45,000.00
210402	Тээвэр, шатахуун	465,100.00	77,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	4,175,759.00	5,882,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		90,000.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	1,224,203.87
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	406,257.00	434,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	406,257.00	434,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	643,784.08	-638,621.87
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	643,784.08	-638,621.87
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,141.00	656,925.70

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	656,925.70	18,303.83
----	---	------------	-----------

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагд сан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,194,632.00	00.00	4,164,632.00
C07	Тайлант үеийн үр дүн	4,194,632.90	00.00	4,194,632.00
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,194,632.00	00.00	4,194,632.00
D08	Тайлант үеийн үр дүн	-885,889.98	00.00	-885,889.98
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,308,742.92	00.00	3,308,742.92

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Мянгад Шим ус ОНӨААТҮГ-н 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг байгууллагын дарга Ж.Бат-очир танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримт бүрдүүлэлтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 07 -наас 2021 оны 03 дугаар сарын 10-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Гантулга хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрхэм зорилго: “Сум орон нутгийн байгууллагуудад цэвэр бохир усны инженерийн шугам сүлжээний арчлалт хамгаалалт засвар үйлчилгээний ажлыг хариуцан чанартай үйлчилгээ хүргэнэ” гэж байгууллагын зорилтыг тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэл: Цэвэр бохир усны инженерийн шугам сүлжээний арчлалт хамгаалалт засвар үйлчилгээний ажил, үйлчилгээг иргэд, байгууллагуудад чанартай хөнгөн шуурхай хүргэх

Тус үйлдвэрийн газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн...”
- Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол

Тухайн байгууллага нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг батлуулж мөрдөөгүй боловч нягтлан бодох бүртгэл нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо байхгүй тул эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөө багатай тул дотоод хяналтын бүтэц бий болгох шаардлагатай гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 29273.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 292.7 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 33283.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 332.8 мянган төгрөгөөр тооцсон болно.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Мянгад сумын Шим ус ОНӨААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 739.5 мянган төгрөг буюу 16.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн, авлага, мөнгөн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
МӨНГӨН ХӨРӨНГӨ	656.9	18.3	(638.6)
АВЛАГА	42.3	74.5	32.2
БАРАА МАТЕРИАЛ	1417.2	1911.6	494.4
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2116.4	2004.4	(112.0)
Дансны өглөг	199.5	345.9	146.4
Хуримтлагдсан ашиг	4194.6	3308.7	(885.9)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4394.1	3654.6	(739.5)

Мөнгөн хөрөнгө оны эхэнд 656.9 мянган төгрөг байсан бол 638.6 мянган төгрөгөөр буурч оны эцэст 18.3 мянган төгрөг болж арилжааны банканд байршиж байна.

Оны эхэнд 42.3 төгрөгийн авлагатай байсан ба оны эцэст 74.5 мянган төгрөгийн авлагатай болж авлага 32.2 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалтай холбогдон гарсан авлага үүссэн байна

Бараа материалын үлдэгдэл оны эхэнд 1417.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст 1911.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон нь өөрсдийн худгаа дулааны шугамтай холбосонтой холбоотой шаардлагатай запаас сэлбэг худалдан авсан байна.

Мянгад Шим ус ОНӨААТҮГ –н үндсэн хөрөнгө нь ЗДТГ-т бүртгэлтэй байдаг байна.

Оны эхэнд нийт 199.5 мянган төгрөгийн өртэй байсан бол оны эцэст 345.9 өр төлбөртэй гарч өр төлбөр 146.4 мянган төгрөгөөр өссөн нь сумын Тамгын газарт илүү төлбөр хийснээс шалтгаалжээ.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	50170,4	51382,2	1211,8
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00	5000.0	5000.0
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	29917.1	27397.6	(2519.4)
Нэмэлт санхүүжилтийн орлого	00	00	00

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1211.8 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн нь ОНХСангаас худгийг дулааны шугамд холбох зардалд 5000.0 мянган төгрөгийн санхүүжилт авсантай холбоотой байна. Урсгал үйл ажиллагааны санхүүжилт урьд оноос 2519.4 мянган төгрөг буюу хувиар буурсан нь ковид -19 цар тахлын арга хэмжээтэй холбоотой цалин хөлс буурснаас нөлөөлжээ.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	29273.7	33283.5	4009.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29273.7	33283.5	4009.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16284.8	15889.9	(394.9)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2007.6	4344.1	2336.5
Цахилгааны зардал	5214.7	5139.1	(75.6)
Хангамж бараа материалын зардал	4746.9	6004.7	1257.8
Нормын хувцас зөөлөн эдлэл	200	0	200
Томилолтын зардал	28	0	(28.0)
Бусад зардал	406,2	434,2	28.0

Нийт зардал өмнөх оноос мянган төгрөгөөр буюу 13.6 хувиар өссөн байна .Энэ нь зардлын өөрчлөлтөд хангамж бараа материалын зардал 1257.8 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2336.5 мянган төгрөгөөр өссөн, цахилгааны зардал 75.6 мянган төгрөгөөр ,бусад зардал 28.0 мянган төгрөгөөр , цалингийн зардал 394.9 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд оруулж хэвшсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар дуудлагаар бохир ус соруулж зайлуулсан машины шатахуун 461.6 мянган төгрөгийн тооцоо бодоогүйтэй холбоотой зөвлөмж өгөгдсөн байна. Тайлант онд зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар и баримтын бүрдлийг хангаж ажиллах 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа илрээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусдаар шийдвэрлэх асуудал илрээгүй болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Үгүй.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд борлуулалт болон худалдан авалтаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.
- 1.2. Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Мянгад шим ус ОНӨААТҮГ-н 2020 оны санхүүгийн тайлан	Аудитын код:
2020			ХОА-2021/5/СТА-ОНӨААТҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Мянгад шим ус ОНӨААТҮГ		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Борлуулалт болон худалдан авалтаа И баримтаар баталгаажуулж байх	0	Зөвлөмж	нягтлан бодогч	Д.Баярмаа
	дүн	0			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР